



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 01323

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн Соёлын ордны
эргэлтийн бус хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын 2020 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн хурлын шийдвэрийн дагуу хавсралтад заасан 1,857,000.00 /нэг сая найман зуун тавин долоон мянга/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данс бүртгэлээс хасахыг Баянзүрх дүүргийн Соёлын ордон /С.Бархас/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй эргэлтийн бус хөрөнгөнөөс, 1 нэр төрлийн 1,127,000.00 /нэг сая нэг зуун хорин долоон мянга/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг Өмчийн ашиглалт, удирдлагын газарт актаар хүлээлгэн өгч, 2 нэр төрлийн 730,000.00 /долоон зуун гучин мянга/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устган, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн Соёлын ордон /С.Бархас/-д үүрэг болгосугай.

3. Татан төвлөрүүлж буй хөрөнгийг худалдан борлуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Төмөрбаатарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

115050000799

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын
 даргын 2020 оны 06 дугаар сарын 29 өдрийн
 0/323 дугаар тушаалын хавсралт

Данснаас хасах эд хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн Соёлын ордон

/төгрөгөөр/

№	Эд хөрөнгийн нэр	Ашигласан жил	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэгдэл үнэ	Эвдрэл гэмтэл	ӨХБЗ-ийн дүгнэлт	НӨАУГ-мэргэжилтний дүгнэлт	ЭБХХХ Комиссын шийдвэр
Машин, тоног төхөөрөмж												
1	Зөөврийн компьютер Dell 5537i3	5	ш	1	1,127,000.00	1,127,000.00	1,127,000.00	-	Эвдэрсэн	актлах	татах	татах
Тоног төхөөрөмжийн дүн						1,127,000.00	1,127,000.00	-				
Программ хангамж												
2	Няравын программ	5	ш	1	250,000.00	250,000.00	250,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах
3	Нягтлан бодох бүртгэлийн программ	10	ш	1	480,000.00	480,000.00	480,000.00	-	Ашиглах боломжгүй	актлах	устгах	устгах
Программ хангамжийн дүн						730,000.00	730,000.00	-				
Нийт данснаас хасах хөрөнгийн дүн						1,857,000.00	1,857,000.00	-				
Үүнээс: Татан төвлөрүүлэх хөрөнгө						1,127,000.00	1,127,000.00	-				
Актлах хөрөнгө						730,000.00	730,000.00	-				